

**Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх,  
харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний  
гүйлгээг мэдээлэх журам**

**НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1 Энэхүү журмын зорилго нь “ҮЦТХТ” ХХК, түүний ажилтнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, сэжигтэй гүйлгээний тайланг Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэ харилцаанд “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль” болон бусад хууль тогтоомж, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан бусад дүрэм, журам, зөвлөмжийг удирдлага болгоно.

**ХОЁР.Журмын нэр томъёо**

2.1 Энэхүү журамд дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1 "Сэжигтэй гүйлгээ" гэж мөнгөний гарал үүсэл, эцсийн хүлээн авагч нь тодорхой бус, эсхүл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн хяналтын механизм бүрдүүлээгүй улсаар дамжуулан хийсэн, түүнчлэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж үзэж байгаа гүйлгээг,

2.1.2 “Бэлэн мөнгөний гүйлгээ” гэж үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, түүнчлэн олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг чек, вексель, үнэт цаас ашиглан хийсэн гүйлгээг,

2.1.3 “Сэжигтэй гүйлгээний тайлан” гэж сэжигтэй гүйлгээ, түүнийг хийж гүйцэтгэсэн этгээдийн тухай мэдээллийг агуулсан Монголбанкнаас баталсан маягтын дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх баримт бичгийг,

2.1.4 “Бэлэн мөнгөний гүйлгээний тайлан” гэж бэлэн мөнгөний гүйлгээний тухай мэдээллийг агуулсан, Монголбанкнаас баталсан маягтын дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх баримт бичгийг,

2.1.5 Санхүүгийн мэдээллийн алба” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлд заасныг,

2.1.6 “Харилцагч” гэж хуулиар олгосон төрөл бүрийн үйлчилгээг Мэдээлэх үүрэгтэй этгээдээс авч байгаа хувь хүн, хуулийн этгээдийг,

2.1.7 “Гүйлгээг түдгэлзүүлэх” гэж сэжигтэй гүйлгээний талаархи мэдээллийг шалгах зорилгоор Санхүүгийн мэдээллийн албанаас гаргасан шийдвэрийн дагуу тухайн гүйлгээг түр зогсоохыг,

2.1.8 “Гүйлгээ” гэж бэлэн мөнгө, үнэт цаас, зээл, өр болон санхүүгийн бусад хэрэгслийг бусдад шилжүүлэх, хүлээн авах, худалдах, худалдан авах,

2.1.9 “Харилцагчийн талаарх мэдээллийг шалгах” гэж харилцагчийг таньж мэдэх, харилцагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэх, зорилгоор харилцагчийн албан ёсны бичиг баримт (иргэний үнэмлэх, гадаад паспорт)-ыг үзэхийг,

2.1.10 “Харилцагчийн тухай албан ёсны бичиг баримт” гэж тухайн харилцагч хувь хүний овог, нэр, төрсөн эсхүл байгуулагдсан он, сар, өдөр, баримтын дугаар бүхий төрийн байгууллагаас олгосон хугацаа нь хүчинтэй бичиг баримт (иргэний үнэмлэх, гадаад паспорт, аж ахуйн бүртгэлийн гэрчилгээ)-ын эх хувийг,

2.1.11 “Хэрэгжилтэд хяналт тавих мэргэжилтэн” гэж Монгол банкны Санхүүгийн мэдээллийн албанд сэжигтэй гүйлгээ, бэлэн болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайланг хүргүүлэх, энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж ажиллах чиг үүрэг бүхий гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон ажилтан,

### **ГУРАВ. Харилцагчийг таньж мэдэх**

3.1 “ҮЦТХТ”ХХК болон түүний ажилтан дараах тохиолдолд харилцагчийн талаарх мэдээллийг шалгана. Үүнд:

3.1.1 Санхүүгийн харилцаа тогтоохын өмнө/данс нээх, байнгын бизнесийн харилцаа тогтоохын өмнө гэх мэт/

3.1.2 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/болон түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийхийн өмнө

3.1.3 Гадаад төлбөр тооцооны гүйлгээ хийхийн өмнө

3.1.4 Богино хугацаанд хийж буй хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн нь 20 сая төгрөгөөс бага боловч нийт үнийн дүн нь 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй бөгөөд СМА-нд мэдээлэх хэмжээнээс доогуур байлгах зорилгоор гүйлгээг хувааж хийж байна гэж үзэх үндэслэл байгаа бол

3.1.5 Тухайн гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж үзэх үндэслэл байгаа бол

3.2 “ҮЦТХТ”ХХК болон түүний ажилтан энэ журмын 3.1-т заасныг хэрэгжүүлэхдээ харилцагчаас дараах мэдээллийг гаргуулан авна.

3.2.1 Харилцагч нь иргэн бол түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар, иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар,

3.2.2 Харилцагч нь хуулийн этгээд бол түүний оноосон нэр, албан ёсны хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, төлөөлөн үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээдийн нэр, хаяг, хувь нийлүүлэгч, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулга, улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар,

3.2.3 Гүйлгээний утга, хүлээн авагчийн тухай мэдээлэл

3.2.4 Бусдын өмнөөс гүйлгээ хийж байгаа тохиолдолд төлөөлүүлж байгаа этгээдийн талаарх мэдээлэл

3.3 Харилцагчийн өгсөн мэдээлэл буруу, ташаа болох нь тогтоогдвол харилцагчаас энэ тухай тайлбар авах бөгөөд тайлбар өгөхөөс татгалзах, хуурамч мэдээлэл, үндэслэлгүй тайлбар өгсөөр байвал уг харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзана.

### **ДӨРӨВ. Гадаад төлбөр тооцооны гүйлгээ, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх**

4.1 Төлбөр Тооцоо Эрсдлийн Удирдлагын Албаны гүйлгээний ажилтан 20 сая төгрөг буюу түүнээс дээш хэмжээний мөнгөн гүйлгээг хийх бүрт гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан мэдээлэх үүрэгтэй ажилтанд мэдэгдэнэ

4.2 Өмчлөх эрх шилжүүлэх гүйлгээний ажилтан шилжүүлж байгаа үнэт цаасны мөнгөн дүн нь 20 сая төгрөг буюу түүнээс дээш хэмжээний үнийн дүнтэй тэнцэх бол гүйлгээ хийх бүрт гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан мэдээлэх үүрэгтэй ажилтанд мэдэгдэнэ

4.3 Хэрэгжилтэд хяналт тавих мэргэжилтэн гадаад төлбөр тооцооны болон бэлэн мөнгөний гүйлгээний тайланг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 7 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хорооны баталсан маягтын дагуу сэжигтэй гүйлгээний тайланг цахим хэлбэрээр эсхүл бичгээр нууцлал, аюулгүй байдлыг хангаж Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлнэ.

4.4 Мөнгөн дүнгээс нь үл хамааран аливаа гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой гэж үзэх үндэслэл байгаа бол уг гүйлгээг 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тайлангийн маягтын дагуу Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.

### **Тав. Хэрэгжилтэд хяналт тавих мэргэжилтний эрх, үүрэг**

5.1 Хэрэгжилтэд хяналт тавих ажилтан дараах эрх эдэлнэ.

5.1.1 Гүйлгээг түдгэлзүүлэх тухай Санхүүгийн мэдээллийн албаны даргын шийдвэрийг хүлээн авмагц нэн даруй хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

5.1.2 шаардлагатай тохиолдолд аюулгүй байдлаа хангуулах талаар арга хэмжээ авахуулах

5.1.3 ажил үүргээ гүйцэтгэхэд саад болж байгаа асуудлаар удирдлагад санал гаргах, шаардлагатай бол Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх

5.2 Хэрэгжилтэд хяналт тавих ажилтан дараах үүрэг хүлээнэ.

5.2.1 Бэлэн мөнгөний гүйлгээ, гадаад төлбөр тооцооны болон сэжигтэй гүйлгээний тайланг Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд батлагдсан маягтын дагуу хуульд заасан хугацаанд хүргүүлнэ.

5.2.2 Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, хууль журмын хэрэгжилтийг хангуулах талаар сургалт зохион байгуулах

5.2.3 Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаанд хяналт тавьж, эрсдлийн үнэлгээний аргаар өргөтгөсөн хяналт тавих,

5.2.4 Мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр хийсэн ажлын тайланг улирал бүр ТУЗ-д танилцуулж хувийг Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлж байх

5.2.5 Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх тохиолдолд түүнийг мөнгө угаах зорилгод ашиглах эрсдлийг судалж санал дүгнэлтээ удирдлагад танилцуулан, шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахуулах,

5.2.6 Харилцагчийн эрсдлийн төвшинг үнэлж, өндөр эрсдэл бүхий харилцагчийн гүйлгээ, дансанд хяналт тавьж ажиллах

5.2.7 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилттэй холбоотой мэдээллээр удирдлагыг хангах

### **ЗУРГАА.Хориглох зүйлүүд**

6.1 Гүйлгээг хийж байгаа ажилтан, байгууллагын удирдлага болон хэрэгжилтэд хяналт тавих ажилтан нь харилцагчийн гүйлгээтэй холбоотой мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлсэн талаар харилцагчид өөрт нь болон гуравдагч этгээдэд ямар нэг байдлаар мэдэгдэхийг,  
6.2 НҮБ-ын тогтоолоор террорист гэж зарлагдсан байгуулага, этгээдийн нэрсийн жагсаалтад нэр нь орсон этгээдэд үйлчилгээ үзүүлэхийг,

6.3 Дотоод гадаадын аливаа санхүүгийн байгууллагатай харилцаа тогтоохын өмнө бодитоор оршдог эсэхийг нь шалгаж, бодитоор оршдоггүй, эсвэл зөвхөн интернэт, цахим хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагатай харилцаа тогтоохгүй байхыг,

6.4 Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлбэл зохих гүйлгээний тайланг батлагдсан маягтын дагуу хугацаанд нь хүргүүлэхгүй байхыг,

### **ДОЛОО. Хариуцлага**

7.1 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд компанийн дотоод журам болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Улаанбаатар хот  
2016 он